

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь: компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээр асуудлаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН:

Цалин урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Наран-Учрал
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ
ТУЗ-ийн ердийн гишүүн М.Болод

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Цалин урамшууллын хороо нь 2024 онд 1 удаа хурал зохион байгуулж, компанийн гүйцэтгэх удирдлагын цалинд өөрчлөлт оруулсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажилласан байна.

Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн 2024 оны 4 сард болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинэчлэгдэн байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нээлттэй хэлэлцүүлэн батлуулсан.

Тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлантай танилцаж, ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийг илүү сайжруулах, цалин урамшууллыг бүтээмжтэй нь уялдуулах тал дээр зөвлөмж өгч ажилласан.

Хүний нөөцийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс жил бүр ажилчдынхаа цалинг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг бөгөөд 2024 оны тухайд цалингийн сангийн хэмжээ өмнөх оноос 30%-иар өссөн ба ажилчдын дундаж цалин 3,000,000 төгрөг байна.

Компани өөрийн дотоод нөөц боломжинд тулгуурлан ажилчдын цалин, урамшууллын хэмжээг шат дараалалтайгаар нэмэгдүүлж, ажилчдын нийгмийн хангамжид дэмжлэг үзүүлж байгаа нь ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллахад маш чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Ажилтныг эзний сэтгэлээр ажилдаа ханддаг болгох, ажилчдын дунд хувьцааны борлуулалт хийх хандлагыг нэмэгдүүлэх, хамаатан садан найз нөхдөөрөө хувьцаа эзэмшигч болох цаашлаад хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх үүднээс компанийн нийт ажилтнуудад чиглэсэн КРІ гүйцэтгэлээс хамаарсан цалин урамшууллыг хүссэн тохиолдолд нь хувьцаа хэлбэрээр олгодог байх мөн байгууллагын дотоод уур амьсгалыг өөрчлөх, багийн дотоод хяналтыг сайжруулах, төлөвлөгөөгөө давуулан биелүүлэх хүсэл тэмүүллийг бий болгох зорилгоор Кайзен аргаар баг ажиллаж, үүнтэй уялдуулан баг хамт олонд багийн гүйцэтгэлээс хамаарсан цалингийн нэмэгдэл олгодог болох зэрэг цаашид хэрэгжүүлбэл зохих саналуудыг хорооны зүгээс гаргаж, Төлөөлөн удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад хүргүүлсэн.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО